

НБД-оон 1993 оны А282-р захирамжаар /77/ *Хүрмийн*



БНМАУ

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

1989 оны *бүгдэл*
сарын *08* өдөр

дугаар *131*

Улаанбаатар
хот

Гадаргын усны хамгаалал-
тыг сайжруулах зарим ар-
га хэмжээний тухай

Нийслэл хотын нутаг дэвсгэрт байгаа гол горхи, булаг шанд, нуурын усны эрэг орчимд вуслан, туслах аж ахуй, гэр, хашаа барих, усны чанар, горимд нөлөөлөх аж ахуйн үйл ажиллагаа явуулснаас ус бохирдох, хомсдох тохиолдол гарч байгааг зогсоож гадаргын усны хамгаалалтыг сайжруулах зорилгоор Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар хотын гадаргын усны хамгаалалтын бүсийн дүрмийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Туул, Сэлбэ, Улиастай, Толгойтын голын хамгаалалтын хориглох бүсийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Голуудын хамгаалалтын хориглох бүсийг газар дээр нь тогтоож, хамгаалалтын бүсэд орсон байгууллага, объектыг судлан 1989 онд багтаан шилжүүлэн нүүлгэх, хязгаарлах бүсэд орсон, түүний горимд харшилж байгаа объектуудыг 1989, 1990 онд багтаан шилжүүлж байрлуулах арга хэмжээ авахыг Архитектур төлөвлөлтийн газар /н. Жадамбаа/, Байгаль, орчныг хамгаалах газар /н. Дагвадорж/-т даалгасугай.

4. Гадаргын усны хамгаалалтын бүсэд цаашид байнгын хяналт тавьж илэрсэн зөрчлийг тухай бүр нь таслан зогсоох арга хэмжээ авч ажиллахыг район, хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Байгаль, орчныг хамгаалах газар /н. Дагвадорж/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *[Signature]* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУУЛАГАТМАН НАРИЙН
БҮЛЭГИЙН ДАРГА *[Signature]* Д.АЛТИА

38

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх
захиргааны 1989 оны 05 дугаар сарын
08 ны өдрийн 131 дугаар тогтоолын
нягдүгээр хавсралт

**УЛААНБААТАР ХОТЫН ГАДАРГЫН УСНЫ
ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ДҮРЭМ**

1. Гадаргын усны /гол, горхи, булаг, шанд, нуур, цөөрөм/ хамгаалалтын бүс гэдэг нь ил задгай усны нөөцийг бохирдох, хомсдохоос хамгаалах зорилгоор тусгай горим тогтоосон дэвсгэр газар юм.

2. Ус хамгаалалтын бүсэд голын татам, эгц, яалуу эрэг, нуурын хөвөө, булгийн эх тэдгээрт шууд холбогдсон гуу жалга, суваг шуудуу хамрагдана. Ундааны усны ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоовдсон газар нь батлагдсан дүрмийн дагуу горимыг мөрдөнө.

3. Гадаргын усны хамгаалалтын бүсийг дотор нь аж ахуйн аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосон ХОРИГЛОХ БҮС, байгалийн ус хөрсөнд бохирдол үзүүлэх үйл ажиллагаа явуулахыг хориглосон ХЯЗГААРЛАХ БҮС гэсэн ялгавартай тогтооно.

4. Гол горхийн ус хамгаалалтын хориглох бүсийг түүний урт, урсацна хэмжээ, бусад хүчин зүйлүүдийг харгалзан гол тус бүрт тогтооно.

5. Булаг шандны усны ундрага, эх авсан эргээс газрын өндөржилтийн дээд талд 200 метр, түүнээс доош ус тогтмол урсдаг 300 метр зайд эргээс хоёр хажуу талд болон нуур цөөрмийн хөвөөнөөс 50 метрт хориглох бүс байна.

6. Гадаргын усанд шууд холбогдсон гуу жалга, суваг шуудуунд ус хамгаалалтын хориглох бүсийг ус урсдаг эргээс 20 метрт тогтооно.

7. Голуудын хориглох бүсийн дотор дараах аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг хориглоно. ҮҮНД:

- а. Хүмүүс түр хугацаагаар болон байнга оршин суух
- б. Мал, гахай болон бусад амьтныг байрлуулах
- в. Аливаа гаралтай хог хаягдал, бохир ус асгах, юм угаах, машин техникт цэвэрлэгээ хийх.

г. Үерийн хамгаалалт, гулдрил, эргийн тохижуулалт хийх, гүүр барих зэрэг байгаль, орчныг хамгаалахаас бусад төрлийн барилга байгууламж барих, тээврийн хэрэгсэл байрлуулах, засварлах.

д. Газрын өнгөн хөрсний эрүүл байдлыг алдагдуулж гэмтээх аливаа ажиллагаа явуулах.

е. Газрын хөрсөнд эрдэс бордоо хэрэглэх, химийн хорт бодис, нефть бүтээгдэхүүн байрлуулах, асгах.

8. Гадаагын усны хамгаалалтын хязгаарлах бүсийг хориглох бүсээс гадагш 100 метрт тогтоох бөгөөд түүний дотор дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Үүнд:

а. Хортон мэрэгч, ургамлын өвчинтэй тэмцэх зорилгоор химийн хорт бодис хэрэглэх.

б. Химийн хорт бодис болон эрдэс бордооны агуулах, химийн хорт бодисын аппарат засварлах талбай байгуулах

в. Мал болон туслах аж ахуйн ферм, бохир ус цэвэрлэх байгууламж, бохир усаар усалгаа хийхэд зориулсан усалалтын систем байгуулах, стог буун хадгалж нөөцлөх.

г. Мал угаах цэг, сүү тосны завод, мал нядалгааны газар байрлуулах.

д. Нефть бааз, мазутын агуулах, шатахуун түгээх газар байрлуулах, машин техник угаах, засварлах

е. Хоёр хаях, бохир ус асгах

ж. Газар хагалах, барилгын эрдэс түүхий эд олборлох

9. Голын ус хамгаалалтын хориглох бүсийг энэ түрэмцэеэс заасан хэмжээгээр тогтоох боломжгүй нөхцөлд эргийн болон үерийн хамгаалалтын далангийн гална ирмэгээр тогтооно.

10. Гадаагын усны хамгаалалтын бүсийн дүрмийг зөрчсөн байгууллага, иргэдэд И.АУ-ын Ус, газар эдлэлбэрийн хууль болон бусад эрх зүйн актад заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11. Энэ дүрмийн биелэлтэд хот, райондын АДХ-ын туслах зөхиргөө, хууль хяналт, сагал, орчныг хамгаалах, ариун цэврийн байгууллагуудаас хяналт тавина.

80

Улаанбаатар хотын АЛХ-ын гүйцэт-
гэх захиргааны 1989 оны дугаар
сарын ны өдрийн дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

ТУУЛ, СЭЛБЭ, УЛНАСТАЙ, ТОЛГОЛЫН ГОЛЫН
ХАМГААЛАЛТЫН БҮС

Голууд	урт /км/	Олон жи- лийн дун- дагч урсгал /м ³ /сек/	хамгаалалтын бүс /голоос 2 тийш/ /м/	Үүнээс хориглох бүс/голоос 2 тийш / /м/
1. Туул	704	25,5	150	50
2. Сэлбэ	31	0,57	130	30
3. Улнастай	33	0,30	130	30
4. Толгойт, Хангайт, Хөлийн гол зэрэг бусад цутгал голууд	2-15	0,05-0,2	125	25